


НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХЭЛТСИЙН ЛАВЛАГАА БЗДХ/ДОХ, СҮРЬЕЭ, ВИРУСТ ГЕПАТИТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ч.АРИУНБОЛОРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
Зорилт 1. “Халдварт өвчний сэргийлэлт, хяналтын урт, дунд, богино хугацааны бодлого, хэрэгжилтийн удирдлага, олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчин, шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчний сэргийлэлт, хяналт, тандалт, хариу арга хэмжээний бодлого, хэрэгжилтийн зохицуулалт, удирдлага зохион байгуулалтаар хангах” хүрээнд							
1	ЗГҮАХТ 2.3.1.2.394 ЭМЯ-ГТ-49 “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх.	Төлөвлөгөөг үнэлж, 2027-2029 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл гарсан байна.	Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн.	2025 онд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалаар “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2025 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 8 зорилтын хүрээнд 135 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Төлөвлөгөөний хэрэгжилт 40%-тай байна.	2025.01.02 2025.12.31	100% 
2	ЗГҮАХТ 2.3.1.2 “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөөг 2 үе шаттайгаар үнэлэх.	Өөрсдийгөө үнэлэх болон ажлын хэсгийн үнэлгээний тайлан гарсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал	Төлөвлөгөөний хэрэгжилтийг ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ-тэй хамтран үнэлсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөөний өөрийн үнэлгээг хийх тухай Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 1	2025.01.02 2025.12.31 	80% үргэлж дууссаар 50%

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
					дүгээр сарын 30-ны өдрийн 2/555 тоот албан бичгийг ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ-д тус тус хүргүүлсэн. Дээрх гурван байгууллагаас ирүүлсэн өөрийн үнэлгээний үр дүнг нэтгэн боловсруулж байна.		
3	ЗГҮАХТ 2.3.1.2 "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" 2026-2029 оны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах.	2026-2029 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл гарсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал	Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан байна.	"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх 2026-2029 оны арга хэмжээний төлөвлөгөө"-г боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тушаалын төслийг боловсруулж байна.	2025.01.02 2025.12.31 байр оюу Б хянагч	50%
4	МУХТЖҮЧ-2.2.1 ЭМЯ-ГТ-27 БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028) боловсруулж батлуулах.	Эрүүл мэндийн сайдын тушаал	Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөний зорилт 4	Төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.	БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-ний төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.	байр оюу Б 2025.01.02 2025.06.30	50% 30%
5	МУХТЖҮЧ-2.2.1 ЭМЯ-ГТ-28 Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлэх. (2025-2028)	Эрүүл мэндийн сайдын тушаал	Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөний зорилт 3	Төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.	"Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө" (2025-2028 он)-ний төслийг боловсруулж батлуулахаар ЭМЯ-ны газар, хэлтсийн дарга нараар хянуулж байна.	2025.01.02 2025.06.30 байр оюу Б	80%

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
6	МУХТЖҮЧ-2.2.1 Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх.	Үнэлгээний тайлан	-	Үнэлгээ хийх удирдамж, ажлын төлөвлөгөө батлагдсан байна.	Монгол Улсад хэрэгжиж буй халдварт өвчинтэй холбоотой зарим хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлын удирдамжийг боловсруулан гуравдугаар хавсралтад Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүнийг тусган Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг ЭМЯ-ны ТНБД-аар батлуулан аргачлалын дагуу холбогдох мэдээллийг цугууллахаар ажиллаж байна.	2025.02.01 2025.05.30 <i>Батлуулсан</i>	100%
7	ЗГҮАХТ 2.3.1.1.388 ЭМЯ-ГТ-22 Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний төв байгуулах.	Үндэсний хэмжээний төв байгуулагдах эрхзүйн орчин бүрдсэн байна.	15 (2013)	Ажлын хэсгийн тушаал батлуулах, холбогдох хурал зохион байгуулсан байна.	- Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/44 дүгээр тушаалаар Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Удирдан чиглүүлэх баг, 2 техникийн ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. - Техникийн ажлын хэсгийн 5 чиглэл 23 заалт бүхий нарийвчилсан төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжүүлж байна. - Удирдан чиглүүлэх багийн хурлыг 2 удаа зохион байгуулж (2 дахь	2025.01.01 2025.12.31	100%

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					хурлыг ДЭМБ-ын зөвлөх мэргэжилтнүүдтэй хамтарсан байдлаар) хурлын шийдвэр гарган хэрэгжүүлж ажиллаж байна. - НЭМАХҮТ байгуулахтай холбоотой тусгай мэргэжлийн төвүүдээс татагдан ажиллах хүний нөөцийн судалгааг албан тушаалын тодорхойлолтод үндэслэн гаргасан. - НЭМАХҮТ-ийн үйл ажиллагааны чиглэл болон бүтцийн зураглалын эхний төсөл гарсан.		

Зорилт 2. ХДХВ/ДОХ/БЗДХ, сүрьеэ, вируст гепатитийн хяналт, сэргийлэлтийн үйл ажиллагааг урт, дунд, богино хугацааны бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд

8	“Эрсдэлт бүлгийн хүн амын дундах ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын хялбаршуулсан тандалт” зохион байгуулах.	Тандалтын тайлан	-	Тандалт зохион байгуулах бэлтгэл ажлын хангасан байна.	2025 оны 5 сард Эрсдэлт бүлгийн хүн амын дунд ХДХВ/ДОХ, Тэмбүүгийн халдвар, эрсдэлт зан үйлийг тодорхойлох хялбаршуулсан тандалт судалгааны тендер сонгон шалгаруулалтыг зарлаж “Эрүүл мэнд форум” ТББ-тай 2025-05-26нд гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 2025-12-30-нд дуусах бөгөөд хялбаршуулсан тандалтын ажил үргэлжилж байна. судалгааны ажлын үр дүнг хүлээж авна.	2025.04.01 2025.10.30	100% хийгээгүй
2	Сүрьеэгийн илрүүлэг зохион байгуулах журам боловсруулж батлуулах.	Батлуулсан журам	ЭМС-ын А/38 дугаар тушаал Сүрьеэгийн тусламж,	Журмын төслийг боловсруулан	Эрүүл мэндийн байгууллагад суурилсан сүрьеэгийн илрүүлэг зохион байгуулах журмын төслийг	2025.01.02 2025.05.01	50%

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
			үйлчилгээ үзүүлэх заавар, журам	батлуулсан байна.	боловсруулан хянаж эцэслэхээр ажиллаж байна.		
3 10	НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөрийн тайланг боловсруулж, хүргүүлэх.	Хүргүүлсэн тайлан	Жил бүрийн эхний 2 улиралд үнэлгээний тайлан гаргаж хүргүүлдэг.	Тайланг боловсруулж хүргүүлнэ.	2025 оны 3 дугаар сарын 25-29 хооронд олон улсын зөвлөхүүдийг урьж тооцооллыг шинэчлэн гаргаж, "Дэлхийн ДОХ-ын хяналт, шинжилгээ-үнэлгээний тайлан"-д Монгол Улсын тайланг хүргүүлсэн.	2025.02.28 2025.03.28	100%
4 11	"ХДХВ/ДОХ, сүрьеэгийн үндэсний хариу арга хэмжээний тогтвортой байдлыг хангах, олон улсын дэмжлэгт санхүүжилтээс Засгийн газрын санхүүжилтэд шилжих шилжилтийн үеийн төлөвлөгөө"-г боловсруулж батлуулах.	Батлуулсан төлөвлөгөө	-	Төлөвлөгөөний төслийн боловсруулсан байна.	Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэтэй тэмцэх төслийн (2024-2026) хүрээнд ДОХ-ын үндэсний зарцуулалтын үнэлгээний ажил хийгдэхээр төлөвлөгдсөн бөгөөд үнэлгээний үр дүнгийн хурлаар бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт нөлөөллийн уулзалт хийхээр төлөвлөсөн.	2025.01.01 2025.12.31	50%
5 12	МУХТЖҮЧ 2.2.2. ЗГҮАХ 2.3.1.1. ЭМЯ-ГТ-27 "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөө (2022-2025)-г хэрэгжүүлж ажиллах.	Төлөвлөгөөнд туссан урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэх арга хэмжээний хэрэгжилтийг хувь	"Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг төлөвлөн 2022-2025 онд хэрэгжүүлж	Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 90%-д хүргэсэн байна.	"Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөө (2022-2025 он)-г 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/577 тушаалаар батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг арга хэмжээний төлөвлөгөө 4 зорилтын хүрээнд 11 үйл ажиллагааны чиглэлээр 34 арга хэмжээг 15 шалгуур үзүүлэлттэйгээр төлөвлөсөн. Арга хэмжээний	2025.01.02 2025.12.31	70%

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
			байна. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 63%-тай байна.		төлөвлөгөө үндэсний хэмжээнд 2023 онд 62.9%, 2024 онд 60.3%, 2025 оны хагас жилээр 61%-ийн хэрэгжилттэй байна.		
13 6	Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг угтан олон нийтэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Жил бүр тус өдрийг угтан арга хэмжээ зохион байгуулдаг	Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг хэмжээ зохион байгуулсан байна.	“Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийн төлөвлөгөөг хүн амд чиглэсэн сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл сурталчилааны хүртээмжийг нэмэгдүүлэх, сүрьеэгийн эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх нь гэсэн үндсэн 2 зорилгийн хүрээнд нийт 47 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн ажилласан. Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийн хүрээнд 21 аймагт сүрьеэгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй нэгжүүдээр дамжуулан сүрьеэ өвчний тухай сургалт сурталчилгаа, ухуулга, нөлөөллийн ажлууд, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа зохион байгуулж 2000 гаруй хүнд тараах материал, брошур, видео контент хүргэж ажилласан байна. Сүрьеэгийн илрүүлгийг нэмэгдүүлэх зорилгоор нэгж бүр урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг зохион байгуулж ЕБС-ийн сурагчид, оюутан залуус, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, амбулаториор үйлчлүүлэгчдийг хамруулсан.	2025.03.01 2025.03.30	100%

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
7	Гепатитын эсрэг дэлхийн өдрийг угтан гепатитын халдвараас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг эрчимжүүлэх.	Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо	Жил бүр тус өдрийг угтан арга хэмжээ зохион байгуулдаг	Гепатитын эсрэг дэлхийн өдрийг угтан гепатитын халдвараас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлын хангасан байна.	Хугацаа болоогүй.	2025.07.01 2025.07.30	-
8	ДОХ/ХДХВ-тэй тэмцэх дэлхийн өдрийг угтан эмч, эмнэлгийн ажилтан, олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.	Сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамруулсан эмч, эмнэлгийн ажилтан, иргэдийн тоо	Жил бүр тус өдрийг угтан арга хэмжээ зохион байгуулдаг	-	Хугацаа болоогүй.	2025.11.01 2025.12.01	-
9	Глобал сангийн Хөтөлбөр зохицуулах нэгжийн төлөвлөгөө, тайланг хянаж албажуулах, үйл ажиллагаанд хяналт тавих, DebToH хөтөлбөрт	Хянасан төлөвлөгөө, тайлангын тоо	-	Тайлан, төлөвлөгөөг хянаж тухай бүр батлуулсан байна.	Глобал сангийн салбар хүлээн авагч нарын 2025 оны 1 болон 2 дугаар улирлын удирдамжийг хянаж ТНБД, Сайдаар батлуулсан. Мөн Өр хөрвүүлэх нэмэлт санжүүжилтийн хүрээнд ХӨСҮТ, ЭМДЕГ, НЭМҮТ, ЭМХТ-үүдэд ЭМС-ийн эрх шилжих тушаалын төслийг боловсруулан батлуулсан.	2025.01.02 2025.12.31	100%

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	ЭМЯ-ны хийх ажлыг төлөвлөгөөнд тусгах.						

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Глобаль сангийн төслийн зохицуулагч сонгон шалгаруулах ажлын хэсэгт орж ажилласан.	Сонгон шалгаруулах ажлын зохион байгуулсан байна.	Өмнөх зохицуулагч өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдсөн.	Зохицуулагч сонгон шалгаруулж ажилд томилох тушаал гаргасан байна.	Төрийн нарийн бичгийн 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/15 дугаар тушаалаар сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулж ажлыг хэсэг 3 удаа хуралдаж сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж төслийн нэгжийн зохицуулагчийг сонгон шалгаруулж ажилд томилох тушаалыг гаруулж ажлыг хүлээлцүүлсэн.	2025.02.10 2025.03.10	100%
2	Глобаль сангийн хөтөлбөр зохицуулах нэгжид ажиллах ДОХ-ын мэргэжилтэн сонгон шалгаруулах ажлын хэсгийн нарийн бичгээр ажилласан	Сонгон шалгаруулах ажлын зохион байгуулсан байна.	Өмнөх мэргэжилтэн өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдсөн.	ДОХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн сонгон шалгаруулсан байна.	Төрийн нарийн бичгийн 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/38 дугаар тушаалаар сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулж ажлыг хэсэг 3 удаа хуралдаж сонгон шалгаруулалтыг зохион байгуулж төслийн нэгжид ажиллах ДОХ-ын мэргэжилтэн сонгон шалгаруулж ажилд томилох тушаалын төслийн боловсруулан ТНБД-д хүргүүлсэн.	2025.04.16 2025.06.16	100%
3	Глобаль сангийн Өр хөрвүүлэх нэмэлт санхүүжилтийн хүрээнд Хөтөлбөр зохицуулах нэгжид	Сонгон шалгаруулах ажлын зохион байгуулсан байна.	Шинэ орон тоо	Төслийн нэгжид ажиллах 4 мэргэжилтэн сонгон шалгаруулсан байна.	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/41 дугаар тушаалаар төслийн нэгжид ажиллах 4 шинэ мэргэжилтэн сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж ажилд томилох тушаалын төслийг боловсруулан ТНБД-д хүргүүлсэн.	2025.04.22	100%

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	ажиллах мэргэжилтэн сонгон шалгаруулах ажлын хэсгийн нарийн бичгээр ажилласан. 4					2025.06.15	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр судалгааны ажил хамтран хийх.	Судалгааны ажлын үр дүн, судалгааны тоо			Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээний харьцуулсан судалгааг 2025 оны 3,4 дүгээр улиралд хийхээр төлөвлөж байна.	2025.06.30 2025.12.01	-
2	Халдварт өвчин болон нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт, семинарт оролцох.	Сургалтын гэрчилгээ			Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн шуурхай удирдлагын төвийн 5 хоногийн дадлага, сургуулилтад 2025 оны 3 дугаар сарын 24-28-ний өдрүүдэд хамрагдсан.	2025.01.01 2025.05.01	100%

ТАЙЛАН БИЧСЭН:

Мэргэжилтэн
(Албан тушаал)

..... /Ч.Ариунболор/
(Нэр, гарын үсэг)

2025.06.16
(Огноо)